



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН ТОЛООЛОГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 21/15

Өргөн

Г Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх  
ашиглуулах журам батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 18 дугаар зүйлийн 18.1.1/ж дэх заалтуудыг үндэслэн ээлжит 04 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх, ашиглуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Засаг дарга /Б.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

В.БАТЖАРГАЛ

Баянговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын ээлжит 04-дүгээр Хуралдааны  
03 дугаар тогтоолын хавсралт



**ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ГАЗРЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ,  
АШИГЛУУЛАХ ЖУРАМ**

1. Энэ журмаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сум, багийн Засаг дарга, Засаг даргын орлогч, сумын Газрын даамал, БОХУБ, МЭҮТ-ийн дарга, мэргэжилтэн нар тухайн нутаг дэвсгэр дэх эзэмшил, ашиглалтанд хяналт тавих, малчид, иргэдийн эдлэх эрх, үүрэг болон журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

2. Журмыг тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сум, багийн Засаг дарга, Засаг даргын орлогч, сумын Газрын даамал, БОХУБ, МЭҮТ-ийн дарга нар хяналт тавьж иргэд, малчид, Бэлчээр Ашиглагчдын Хэсэг, Бэлчээр Ашиглагчийн бүлэг дагаж мөрдөнө.

**3. Сумын Иргэдийн Төлөөлөгчийн Хурал өвөлжөө, хаваржааны зориулалтаар газрыг эзэмшиж, ашиглахад дараах чиглэлээр хяналт тавина.**

3.1. Өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмших, ашиглах газрыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлах

3.2. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлж, ашиглуулахаар батлагдсан газар олголтын хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

**4. Сумын Засаг дарга өвөлжөө, хаваржааны зориулалтаар газрыг эзэмшиж, ашиглахад дараах чиглэлээр хяналт тавьж хэрэгжүүлж ажиллана.**

4.1. Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмших, ашиглах талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах

4.2. Малчид өөр хоорондоо өвөлжөө, хаваржаагаа үнэ тохиролцон зардаг асуудлыг зогсоож Бэлчээр ашиглагчдын хэсэг, Бэлчээр ашиглагчдын бүлгийн шийдвэр, саналыг үндэслэн багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн тохиолдолд баталгаажуулна.

4.3. Өвөлжөө, хаваржааны асуудлаар гарсан аливаа маргааныг шийдвэрлэн багийн Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийн талаар гарсан санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх

**5. Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга өвөлжөө, хаваржааны зориулалтаар газрыг эзэмшиж, ашиглахад дараах чиглэлээр хяналт тавьж хэрэгжүүлнэ.**

5.1. Малчид иргэдээс өвөлжөө, хаваржааны талаар ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч багийн Иргэдийн Нийтийн Хурлаар шийдвэрлэж сумын Засаг даргад уламжлах

5.2. Өвөлжөө, хаваржааны талаар гарсан маргааныг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар шийдвэрлэх, шийдвэрлэж чадаагүй тохиолдолд сумын Засаг даргад уламжлах

**6. Сумын газрын даамал болон бусад мэргэжилтэнүүд өвөлжөө, хаваржааны зориулалтаар газрыг эзэмшиж, ашиглахад дараах чиглэлээр хяналт тавьж хэрэгжүүлнэ.**

6.1. Шинээр өвөлжөө, хаваржааны зориулалтаар олгох газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд олгох газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж солбицолыг тогтоож Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах

6.2. Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарсан сумын Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх

6.3. /Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх, ашиглуулах талаарх хууль тогтоомж зөрчсөн иргэнд багийн Иргэдийн Нийтийн Хурлаас гаргасан тогтоолыг сумын Засаг даргад уламжилж шийдвэрлүүлэх /хасах/

6.4 Сумын Засаг даргын шийдвэрийг үндэслэн өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ байгуулах, эрхийн гэрчилгээ олгож гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих

### **7. Өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшиж ашиглаж байгаа малчдын эрх, үүрэг**

7.1. Өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшиж, ашиглах талаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж гаргасан журам, багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоол, сумын Засаг даргын шийдвэрийг биелүүлэх

7.2. Өвөлжөө, хаваржааны зориулалтаар олгосон газрыг журамд заасны дагуу эзэмшиж, ашиглана.

### **8. Өвөлжөө, хаваржааны зориулалтаар олгосон газрыг эзэмших, ашиглах талаар**

8.1. Хот айл нэг өвөлжөө, нэг хаваржаатай байна.

8.2. Шинээр өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар олгохдоо эзэмшиж, ашиглаж байгаа өвөлжөө, хаваржааны газраас 3 км ба түүнээс дээш километрт олгоно.

8.3. Шинээр өрх тусгаарласан 100 –аас дээш малтай малчин өрхөд өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшүүлж, ашиглуулна.

8.4. Шинээр өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар олгох ба, олгосон газрыг эрх шилжүүлэн эзэмшүүлж, ашиглуулахдаа багийн Иргэдийн Нийтийн Хурал 70-80 хувийн ирцтэй хуралдаж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8.5. хоёроос дээш өвөлжөө, хаваржаа эзэмшиж, ашиглаж байгаа иргэдэд мэдэгдэл хүргүүлэн, багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж эзэмших эрхийг хүчингүй болгох, дараагийн иргэнд эрх шилжүүлэн эзэмшүүлэхээр сумын Засаг даргад уламжлана.

8.6. Шинээр өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшүүлж, ашиглуулахаар шийдвэр гараагүй газарт хороо, хашаа барихыг хориглоно.

8.7. Эзэмшиж ашиглаж байгаа газар дээрхи өөрийн хөрөнгийг бусдад худалдах тохиолдолд тухайн газрыг холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авсны дараа эрх шилжүүлэн эзэмшүүлнэ.

8.8. Эзэмшиж, ашиглаж байгаа өвөлжөө, хаваржааны газарт ариутгал, халдваргүйжүүлэлтийг жил болгон хийлгэнэ.

8.9. Өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байсан иргэн нас барсан, сураггүй алга болсон тохиолдолд 3 сарын дотор үргэлжлүүлэн эзэмших эрх бүхий иргэн хүсэлтээ Газрын даамалд гаргаж шийдвэрлүүлэнэ.

8.10. Хоёр жил дараалан эзэмшиж, ашиглаагүй өвөлжөө, хаваржааны газрын судалгаа гаргаж нотлох баримтыг цуглуулж арга хэмжээ авна.

8.11. Сум орон нутагт байнга оршин суудаггүй буюу шилжсэн малчин, мал бүхий иргэний эзэмшиж, ашиглаж байгаа өвөлжөө, хаваржааны газрын эзэмших, эрхийн гэрчилгээ, гэрээг хүчингүй болгож дахиж олгохгүй.

8.12. Тухайн орон нутагт байнга оршин суудаг малчин, мал бүхий иргэн өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааг түр эзэмшүүлж байгаа иргэнтэй гэрээ хийж нэг хувийг өөрийн хувийн хэрэгт хавсаргана.

8.13. Тухайн багт байнгын оршин суугч, жилийн 4 улиралд мал маллаж буй малчин иргэнд өвөлжөө, хаваржааны газрыг олгож эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ байгуулж гэрчилгээжүүлнэ.

8.14. 200- аас дээш малтай мал бүхий иргэнд харьяа багийн нутаг дэвсгэрт өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар олгож эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ байгуулж гэрчилгээжүүлнэ.

8.15. Отрын бүс нутагт өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшил, ашиглалтын гэрчилгээ олгохгүй.

8.16. Малчин өрх тухайн оршин суугаа багтаа өвөлжөө, хаваржаа эзэмшиж, ашиглана.

#### **9. Урамшууллын арга хэмжээ**

9.1. Нутгийн зааг хил хязгаарыг тэлж, ашиглагддаггүй бэлчээрт нутаглаж байгаа малчин өрхөд татварын хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх, нийгмийн үйлчилгээнд хамруулах.

9.2. Малжуулах арга хэмжээ, материаллаг баазаа бэхжүүлэхэд туслах,

#### **10. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.**

10.1. Сум, багийн Засаг дарга нь батлагдсан журмыг зөрчсөн иргэн, малчинд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32.1, Газрын тухай хуулийн 40.1.1, 40.1.3, 40.1.5, 40.1.6 болон бусад холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.

#### **11. Журмыг мөрдөж хэрэгжүүлэх**

11.1. Уг журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж сумын газар нутагт иргэд, малчид дагаж мөрдөнө.